

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Кромарти Драйв 170, 200 тоот  
Дартмут Нова Скошиа, В3А 4S5

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Компани”) нь Хувьцаа эзэмшигчдийн (“Хувьцаа эзэмшигчид”) ээлжит хурал (“Хурал”)–ыг 2026 оны 5-р сарын 28-ны өдөр Канад Улсын Нова Скошиа муж, Халифакс хотын 1969 Апшер Уотер гудамж, МкИннес Купер Тауэр, 1300 тоот хаягт 10:00 цагт (Атлантын цагаар) дараах зорилгоор зохион байгуулна. Үүнд:

- (i) Компанийн 2025 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн, аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг танилцуулах; Санхүүгийн тайлантай холбоотойгоор санал хураалт явуулах шаардлагагүй бөгөөд санал хураах төлөвлөгөөгүй болно
- (ii) Компанийн ирэх жилийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн гишүүдийг сонгох;
- (iii) Компанийн ирэх жилийн аудиторыг томилох ба ТУЗ-д аудиторын цалин урамшууллыг тогтоох эрхийг олгох;
- (iv) Компанийн хувьцаанд суурилсан урамшууллын цогц хөтөлбөрийн хүрээнд хуваарилагдаагүй эрхийг баталгаажуулах;
- (v) Хурал зохион байгуулагдахаас өмнө хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудлууд багтана.

Хурлын өмнө хэлэлцэхээр санал болгож буй асуудлын дэлгэрэнгүйг Удирдлагын Мэдээллийн Танилцуулга (“Танилцуулга”)–д тусгаж, энэхүү хурлын мэдэгдэл (“Хурлын мэдэгдэл”)–ийн хавсралт болгон хүргүүлнэ.

Танилцуулгад тусгаснаас гадна, 2026 оны 4-р сарын 23-ны ажлын өдөр дуусгавар болох үеийн байдлаар бүртгэлтэй Хувьцаа эзэмшигчид энэхүү Хурлын мэдэгдлийг хүлээн авах, түүнчлэн Хурлын үеэр санал өгөх эрхтэй байна. **Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийн** хувиар Хуралд санал өгөх эрхээ баталгаажуулахын тулд хуралд биечлэн оролцох эсхүл оролцохгүй эсэхийг үл харгалзан хавсаргасан саналын хуудасны загварыг бөглөн гарын үсэг зурж, огноог тавьж буцаан илгээнэ. Уг саналын хуудсыг илгээх нь Хуралд биечлэн санал өгөх эрхэд саад учруулахгүй. Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг Компанийн бүртгэгч агент “Компьютершэйр Инвестор Сэрвис Инк / Computershare Investor Services Inc” компани нь 2026 оны 5-р сарын 26-ны өдрийн (Атлантын цагаар) 10:00 цагаас өмнө хүлээн авсан байх ёстой. Бүртгэлтэй хувьцаа эзэмшигч нь бөглөсөн саналын хуудсаа “Computershare Investor Services Inc.” компани руу дараах байдлаар илгээж болно. Үүнд:

- (a) Битүүмжилсэн дугтуйнд хийж **шуудангаар** илгээх;
- (b) Хавсралт саналын хуудасны загвар дээрх **утасны дугаараар** болон **цахим шуудангаар** илгээх; эсвэл
- (c) Computershare Proxy Department, 8th Floor, 100 University Avenue, Toronto, Ontario, M5J 2Y1 хаягт баталгаат шуудангаар, биечлэн эсвэл буухиа шуудангаар ирүүлж болно.

Хувьцаа нь зуучлагчийн нэр дээр бүртгэгдсэн **Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч** нь зуучлагчийн ирүүлсэн маягтыг анхааралтай мөрдөх хэрэгтэй. Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийн загварыг буцаан илгээх дэлгэрэнгүй зааварчилгааг хавсралт танилцуулгын 2-р нүүрнээс авах боломжтой.

Хэрэв та Хуралд зориулсан нэгээс дээш тооны санал өгөх маягт болон зааварчилгаа хүлээн авсан бол энэ нь таны хувьцаа нэгээс олон тооны нэр дээр бүртгэгдсэнтэй холбоотой байж болно. Таны бүх хувьцаа саналын эрхтэй байхын тулд хүлээн авах бүх санал өгөх маягт ба зааварчилгаа тус бүрт гарын үсэг зурж буцаан илгээх шаардлагатай.

2026 оны 4-р сарын 27-ны өдөр; Нова Скошиа муж, Халифакс хот, Дартмут.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРИЙН ДАГУУ

Петер К. Акерли (гарын үсэг зурав)  
Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал